



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл дэх “COVID-19” цар тахлын нөлөө /2021 оны II улирал/

УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,  
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар  
Утас: (+976) 77121286  
Вэб хуудас: [www.rilsp.gov.mn](http://www.rilsp.gov.mn)

## **АГУУЛГА**

<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	2
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	3
<b>БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ</b> .....	4
АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН .....	4
БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН .....	6
АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА .....	7
АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН .....	9
ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА .....	11
<b>БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ</b> .....	14
ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА .....	14
ДААТГУУЛАГЧ .....	15
ШИМТГЭЛИЙН ОРЛОГО .....	16
АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ .....	17
<b>БҮЛЭГ 3. ДҮГНЭЛТ</b> .....	19

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

ХҮСНЭГТ 1.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, сарын эхэнд болон сарын эцэст ....	4
ХҮСНЭГТ 1.2 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, насны бүлгээр ....	5
ХҮСНЭГТ 1.3 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, боловсролын түвшнээр, .....	6
ХҮСНЭГТ 1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сарын эхэнд болон сарын эцэст	6
ХҮСНЭГТ 1.5 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, насны бүлгээр	7
ХҮСНЭГТ 1.6 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, боловсролын түвшин .....	7
ХҮСНЭГТ 1.7 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, өсөн нэмэгдэхээр .....	8
ХҮСНЭГТ 1.8 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эхний хагас жил, ЭЗҮА-ны салбарын ангиллаар .....	8
ХҮСНЭГТ 1.9 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эхний хагас жил, ажил мэргэжлийн ангиллаар .....	9
ХҮСНЭГТ 1.10 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	9
ХҮСНЭГТ 1.11 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, ЭЗҮА-ны салбарын ангиллаар .....	10
ХҮСНЭГТ 1.12 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, ажил мэргэжлийн ангиллаар .....	11
ХҮСНЭГТ 2.1 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	14
ХҮСНЭГТ 2.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, байгууллагын хэлбэр, өсөн нэмэгдэхээр .....	14
ХҮСНЭГТ 2.3 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	15
ХҮСНЭГТ 2.4 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, байгууллагын хэлбэр, өсөн нэмэгдэхээр .....	15
ХҮСНЭГТ 2.5 САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	15
ХҮСНЭГТ 2.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг, өсөн нэмэгдэхээр .....	16
ХҮСНЭГТ 2.7 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, сангийн төрлөөр, тэрбум төгрөг, өсөн нэмэгдэхээр .....	17
ХҮСНЭГТ 2.8 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО, өсөн нэмэгдэхээр .....	18
ХҮСНЭГТ 2.9 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, сая төгрөг, өсөн нэмэгдэхээр .....	18

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

ЗУРАГ 1.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 6-р сарын байдлаар, мянган хүн .....	4
ЗУРАГ 1.2 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙ ТОО, 2019-2021 оныг сараар харьцуулснаар	5
ЗУРАГ 1.3 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙ ТОО, сар бүрээр .....	5
ЗУРАГ 1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 6-р сарын байдлаар, мянган хүн .....	7
ЗУРАГ 1.5 ТУХАЙН САРД АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД .....	9
ЗУРАГ 1.6 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ХУВЬ, сар бүрээр.	11
ЗУРАГ 1.7 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГЫГ ЭРЭЛТЭЭР ХАНГАСАН ХУВЬ, сар бүрээр .....	12
ЗУРАГ 1.8 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, эхний хагас жил, ЭЗҮА-ны салбарын ангилал, хувиар .....	12
ЗУРАГ 1.9 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, эхний хагас жил, ажил мэргэжлийн ангилал, хувиар .....	13
ЗУРАГ 2.1 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, мянган хүн .....	16
ЗУРАГ 2.2 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг .....	17
ЗУРАГ 2.3 НЭГ ХҮНД ЗАРЦУУЛСАН ДУНДАЖ ХӨРӨНГӨ, сая төгрөг, сараар .....	18

## БҮЛЭГ 1.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ

### АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭД

2021 оны эхэнд 29.9 мянган хүн ажил хайж байсан боловч 3-р сарын эцсийн байдлаар 25.1 мянга болж 4.8 мянган хүнээр буурсан бол 6-р сарын байдлаар 27.0 мянга болж өмнөх улирлаас 1.9 мянган хүнээр өссөн байна. 2021 оны эхний хагас жилд ажил хайж байгаа иргэд 45.4 хүнээр нэмэгдэж, 48.4 мянган хүнээр хасагдсан байна. Нийт хасагдсан иргэдийн 24.6 хувь нь ажилд зуучлагдсан бөгөөд цэвэр дүнгээр ажил хайгч иргэд оны эхэн үеэс 3.0 мянга буюу 9.9 хувиар буурсан байна.


#### ХҮСНЭГТ 1.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, сарын эхэнд болон сарын эцэст

Сар	Ажил хайж байгаа иргэд /сарын эхэнд/	Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэд	Тайлант хугацаанд хасагдсан иргэд	Ажилд зуучлагдан орсон иргэд	Ажил хайж байгаа иргэд /сарын эцэст/
I сар	29 952	6 446	10 364	1 061	26 034
II сар	26 034	5 408	8 112	584	23 330
III сар	23 330	8 573	6 798	1 910	25 105
IV сар	25 105	5 730	5 555	1 117	25 280
V сар	25 280	7 956	6 890	2 587	26 346
VI сар	26 346	11 326	10 681	4 646	26 991

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 6-р сарын эцэст ажил хайгч иргэний тоо 27.0 мянга болж өмнөх оны мөн үеэс 3.3 мянга буюу 11.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин тухайн сард нэмэгдсэн болон хасагдсан иргэдийг авч үзвэл ажил хайж байгаа иргэд 11.3 мянгаар нэмэгдэж өмнөх оны мөн үеэс 2.1 мянга буюу 22.4 хувиар өссөн байна. Мөн тухайн сард ажил хайж байгаа иргэд 10.7 мянгаар хасагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.6 мянга буюу 6.3 хувиар өссөн байна. Хасагдсан ажил хайж байгаа иргэдээс 4.6 мянган иргэн ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.6 мянга буюу 13.9 хувиар өссөн байна. 2021 оны 6-р сарын эцсийн байдлаар ажил хайж байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байгаа боловч тухайн сард нэмэгдсэн, хасагдсан болон ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. Оны эхэн үеэс иргэдийн ажил хайх сонирхол бага байсан боловч 6-р сарын байдлаар иргэдийн ажил хайх хөдөлгөөн нэмэгдэж байгаа нь харагдаж байна.


#### ЗУРАГ 1.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 6-р сарын байдлаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Доорх зурагт ажил хайж байгаа иргэдийн тоог 2019 он, 2020 он, 2021 оны эхний зургаан сарын байдлаар харуулсан. 2020 оны эхний зургаан сарын байдлаар ажил хайж байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүчтэй өөрчлөлт ороогүй байна. Харин 2021 оны эхний зургаан сарын байдлаар ажил хайж байгаа иргэдийн тоо өмнөх хоёр оны мөн үеэс дунджаар 23.9 хувиар бага байна.


ЗУРАГ 1.2 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙ ТОО, 2019-2021 оныг сараар харьцуулснаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн тоо өмнөх оны эхэнд буюу 2020 оны 1-р сард 37.0 мянга байсан бөгөөд цаашид буурсаар 2021 оны 6-р сард 26.3 мянга хүрсэн байна. 2020 оны 10-р сараас бага зэрэг өссөн боловч 12-р сараас буцаад буурсан нь Ковид-19 цар тахлыг дотоодод халдварлаж эхэлсэн цаг хугацаатай давхцаж байгаа юм. 2021 оны 3-р сард ажил хайж байгаа иргэд хамгийн багадаа хүрээд өссөн байна.

ЗУРАГ 1.3 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙ ТОО, сар бүрээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийг насны бүлгээр өмнөх оны мөн үетэй харьцуулбал 15-24 насныхан 1.5 мянга буюу 24.7 хувь, 25-34 насныхан 0.8 мянга буюу 7.5 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 1.2 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, насны бүлгээр

Насны бүлэг	2020 он	Эзлэх хувь	2021 он	Эзлэх хувь	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>30 320</b>	<b>100</b>	<b>26 991</b>	<b>100</b>	<b>-3 329</b>	<b>-11.0</b>
15-24	5 990	19.8	4 510	16.7	-1 480	-24.7
25-34	10 413	34.3	9 637	35.7	-776	-7.5
35-44	7 802	25.7	7 153	26.5	-649	-8.3
45-54	4 856	16.0	4 389	16.3	-467	-9.6
55-59	941	3.1	949	3.5	8	0.9
60+	318	1.0	353	1.3	35	11.0

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийг боловсролын түвшин бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсролгүй иргэд 24.3 хувиар, бага боловсролтой иргэд 16.8 хувиар, бүрэн дунд болон техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд 14.1 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 1.3 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, боловсролын түвшнээр,

Боловсролын түвшин	2020 он	Эзлэх хувь	2021 он	Эзлэх хувь	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>30 320</b>	<b>100</b>	<b>26 991</b>	<b>100</b>	<b>-3 329</b>	<b>-11.0</b>
Боловсролгүй	469	1.5	355	1.3	- 114	-24.3
Бага	685	2.3	570	2.1	- 115	-16.8
Суурь	2 037	6.7	1 771	6.6	- 266	-13.1
Бүрэн дунд	17 218	56.8	14 783	54.8	-2 435	-14.1
Техникийн болон мэргэжлийн	2 033	6.7	1 744	6.5	- 289	-14.2
Тусгай мэргэжлийн дунд	1 323	4.4	1 187	4.4	- 136	-10.3
Дипломын болон бакалаврын дээд	6 323	20.9	6 352	23.5	29	0.5
Магистр, доктор	232	0.8	229	0.8	- 3	-1.3

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоон мэдээллээс харахад 2021 оны 6-р сарын эхэнд 17.4 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байсан бол тайлант хугацаанд 7.6 мянган хүнээр нэмэгдэж, 7.3 мянган хүнээр хасагдаж, цэвэр дүнгээр 0.2 мянган хүнээр өссөн байна. 2021 оны 6-р сарын эцэст 17.6 мянган бүртгэлтэй ажилгүй хүн байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 мянга буюу 9.8 хувиар буурчээ. Тайлант хугацаанд хасагдсан бүртгэлтэй ажилгүй иргэдээс 41.9 хувь нь ажилд зуучлагдсан байна.

ХҮСНЭГТ 1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сарын эхэнд болон сарын эцэст


Сар	Бүртгэлтэй ажилгүй иргэд /сарын эхэнд/	Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэд	Тайлант хугацаанд хасагдсан иргэд	Ажилд зуучлагдан орсон иргэд	Бүртгэлтэй ажилгүй иргэд /сарын эцэст/
II	16 472	3 583	4 593	307	15 462
III	15 462	5 676	4 363	1 063	16 775
IV	16 775	3 640	3 726	643	16 689
V	16 689	5 390	4 652	1 618	17 427
VI	17 427	7 556	7 333	3 071	17 650

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 6-р сард бүртгэлтэй ажилгүй иргэний тоо 7.6 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.9 мянга буюу 34.4 хувиар өссөн байна. Тухайн сард ажил хайж байгаа иргэд 7.3 мянгаар хасагдаж, өмнөх оны мөн үеэс 1.5 мянга буюу 25.4 хувиар өссөн байна. Тухайн сард 3.1 мянган иргэн ажилд зуучлагдсан байна. 2021 оны 1-р сард бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 18.1 мянга байсан бол 6-р сарын эцэст 17.6 мянга болж 0.4 мянга буюу 2.5 хувиар буурсан дүнтэй байна.



**ЗУРАГ 1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 6-р сарын байдлаар, мянган хүн**



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн насны бүлгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15-24 насныхан 0.8 мянга буюу 21.5 хувиар, 25-34 насныхан 0.6 мянга буюу 8.3 хувиар, 35-44 насныхан 0.3 мянга буюу 6.3 хувиар буурсан байна.

**ХҮСНЭГТ 1.5 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, насны бүлгээр**

Насны бүлэг	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тогоо	Эзлэх хувь	Тогоо	Эзлэх хувь	Тогоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>19 563</b>	<b>100.0</b>	<b>17 650</b>	<b>100.0</b>	<b>-1 913</b>	<b>-9.8</b>
15-24	3 603	18.4	2 829	16.0	-774	-21.5
25-34	7 222	36.9	6 620	37.5	-602	-8.3
35-44	4 946	25.3	4 632	26.2	-314	-6.3
45-54	3 007	15.4	2 747	15.6	-260	-8.6
55-59	585	3.0	603	3.4	18	3.1
60+	200	1.0	219	1.2	19	9.5

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд боловсролгүй, бага болон техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд хамгийн их буурсан дүнтэй байна.

**ХҮСНЭГТ 1.6 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, боловсролын түвшин**

Боловсролын түвшин	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тогоо	Эзлэх хувь	Тогоо	Эзлэх хувь	Тогоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>19 563</b>	<b>100.0</b>	<b>17 650</b>	<b>100.0</b>	<b>-1913</b>	<b>-9.8</b>
Боловсролгүй	276	1.4	216	1.2	-60	-21.7
Бага	454	2.3	377	2.1	-77	-17.0
Суурь	1 299	6.6	1 113	6.3	-186	-14.3
Бүрэн дунд	10 266	52.5	8 945	50.7	-1321	-12.9
Техникийн болон мэргэжлийн	1 544	7.9	1 246	7.1	-298	-19.3
Тусгай мэргэжлийн дунд	923	4.7	802	4.5	-121	-13.1
Дипломын болон бакалаврын дээд	4 644	23.7	4 775	27.1	131	2.8
Магистр, доктор	157	0.8	176	1.0	19	12.1

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

**АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА**

2021 оны эхний хагас жилд нийт 20.3 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 мянга буюу 27.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2021 оны 6-р сард 6.8 мянган ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 0.1 мянга буюу 2.0 хувиар өссөн байна.

## ХҮСНЭГТ 1.7 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	2 795	2 795	1 334	1 334	-1 461	-52.3
II	5 098	2 303	2 610	1 276	-2 488	-48.8
III	7 595	2 497	6 413	3 803	-1 182	-15.6
IV	12 055	4 460	9 007	2 594	-3 048	-25.3
V	21 358	9 303	13 538	4 531	-7 820	-36.6
VI	28 036	6 678	20 352	6 814	-7 684	-27.4

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний хагаст ирсэн ажлын байрны захиалгын 34.0 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбараас, 16.4 хувь нь барилгын салбараас, 8.6 хувь нь уул уурхай, олборлолтын салбараас, 6.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ирсэн байна.

Салбар бүрээс ирсэн ажлын байрны захиалгыг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсрол болон үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар буурсан дүнтэй байгаа бол уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбараас ирсэн ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.

Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 7.7 мянгаар буурсны 71.5 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, 19.2 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар эзэлж байна.

## ХҮСНЭГТ 1.8 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эхний хагас жил, ЭЗҮА-ны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>28 036</b>	<b>20 352</b>	<b>-7 684</b>	<b>-27.4</b>
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 525	1 012	- 513	-33.6
Уул уурхай, олборлолт	980	1 745	765	78.1
Боловсруулах үйлдвэрлэл	1 349	1 255	-94	-7.0
Барилга	3 860	3 335	-525	-13.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	794	1 105	311	39.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	388	314	-74	-19.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	255	503	248	97.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 375	1 103	-272	-19.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2 159	686	-1473	-68.2
Боловсрол	875	746	-129	-14.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	617	714	97	15.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12 429	6 934	-5495	-44.2
Бусад	1 430	900	- 530	-37.1

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний хасагт ирсэн ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл, 3.4 мянга (16.8 хувь) нь мэргэжилтэн, 3.9 мянга (19.2 хувь) нь энгийн ажил, мэргэжил, 3.6 мянга (17.6 хувь) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил

үйлчилгээний ажилтан, 2.8 мянга (14.0 хувь) нь худалдаа, үйлчилгээний ажилтны захиалга байна. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар буурсан бөгөөд ажил мэргэжил бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүгд буурсан дүнтэй байна.

**ХҮСНЭГТ 1.9 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эхний хагас жил, ажил мэргэжлийн ангиллаар**

Ажил мэргэжлийн ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>28 036</b>	<b>20 352</b>	<b>-7684</b>	<b>-27.4</b>
Менежер	994	1 245	251	25.3
Мэргэжилтэн	5 467	3 427	-2040	-37.3
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн	1 969	1 642	-327	-16.6
Контор, үйлчилгээний ажилтан	1 548	1 068	-480	-31.0
Худалдаа, үйлчилгээний ажилтан	4 326	2 845	-1481	-34.2
ХАА, ой, загас агнуурын ажилтан	878	796	-82	-9.3
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	4 838	3 589	-1249	-25.8
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	1 909	1 580	-329	-17.2
Энгийн ажил, мэргэжил	5 643	3 905	-1738	-30.8
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	464	255	-209	-45.0

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

**АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН**

2021 оны эхний хагас жилд 11.4 мянган иргэн ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.8 мянга буюу 25.1 хувиар буурсан байна. Харин 2021 оны 6-р сард 4.6 мянган иргэн ажилд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.6 мянга буюу 13.9 хувиар өссөн байна.


**ХҮСНЭГТ 1.10 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр**

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	1 398	1 398	572	572	- 826	-59.1
II	2 695	1 297	1 156	584	- 1 539	-57.1
III	4 489	1 794	3 066	1 910	- 1 423	-31.7
IV	7 266	2 777	4 183	1 117	- 3 083	-42.4
V	11 171	3 905	6 770	2 587	- 4 401	-39.4
VI	15 250	4 079	11 416	4 646	- 3 834	-25.1

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажилд зуучлагдсан иргэдийг 2020 он болон 2021 оны эхний зургаан сар бүрээр харьцуулбал 3-р болон 6-р сард өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. 4-р сард ажилд зуучлагдсан иргэний тоо өмнөх оны мөн үеэс 2 дахин бага байгаа нь олон нийтийн хөл хориотой байсантай холбоотой байх магадлалтай юм.

**ЗУРАГ 1.5 ТУХАЙН САРД АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД**



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 30.3 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 13.9 хувь нь барилгын салбарт, 9.0 хувь нь уул уурхайн, олборлолтын салбарт, 7.0 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, 6.9 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт зуучлагдсан байна.

Ажилд зуучлагдсан иргэдээс ХАА, ойн аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, боловсрол, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс буурсан байгаа бол уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.

Ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 3.8 мянгаар буурсан бөгөөд 19.7 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбар, 42.9 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар эзэлж байна.

ХҮСНЭГТ 1.11 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, ЭЗҮА-ны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>15 250</b>	<b>11 416</b>	<b>-3 834</b>	<b>-25.1</b>
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,	1 123	794	- 329	-29.3
Уул уурхай, олборлолт	616	1 023	407	66.1
Боловсруулах үйлдвэрлэл	865	719	- 146	-16.9
Барилга	2 101	1 590	- 511	-24.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	527	560	33	6.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	324	139	- 185	-57.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 201	788	- 413	-34.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 295	539	- 756	-58.4
Боловсрол	705	570	- 135	-19.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	459	505	46	10.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5 103	3 457	-1 646	-32.3
Бусад	931	732	- 199	-21.4

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний хагаст ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл 1769 хувь нь мэргэжилтэн, 18.9 хувь нь энгийн ажил, мэргэжил, 17.9 хувь нь мэргэжилтэн, 17.6 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 12.3 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл мэргэжилтэн, техникч болон туслах /дэд мэргэжилтэн, контор, үйлчилгээний ажилтан, худалдаа, үйлчилгээний ажилтан, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, энгийн ажил, мэргэжлийн чиглэлээр ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс буурсан бол менежер, ХАА, ой, загас агнуурын ажилтан, зэвсэгт хүчний ажил, мэргэжлийн чиглэлээр ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна.

Энгийн ажил мэргэжил болон мэргэжилтэн чиглэлээр ирсэн ажлын байрны захиалга хамгийн их буурсан буюу нийт бууралтын 25.5 хувь нь мэргэжилтэн, 69.8 хувь нь энгийн ажил мэргэжил бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 1.12 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, эхний хагас жил, ажил мэргэжлийн ангиллаар


Ажил мэргэжлийн ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>15 250</b>	<b>11 416</b>	<b>-3 834</b>	<b>-25.1</b>
Менежер	529	649	120	22.7
Мэргэжилтэн	3 022	2 044	- 978	-32.4
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн	1 107	912	- 195	-17.6
Контор, үйлчилгээний ажилтан	896	442	- 454	-50.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	1 881	1 406	- 475	-25.3
ХАА, ой, загас агнуурын ажилтан	688	709	21	3.1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	2 428	2 004	- 424	-17.5
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	944	914	- 30	-3.2
Энгийн ажил, мэргэжил	3 658	2 154	-1 504	-41.1
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	97	182	85	87.6

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

## ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА

2021 оны 1-р сард 29.9 мянган иргэн ажил хайж байсны 1.0 мянга буюу 3.5 хувь нь ажилд зуучлагдсан бол 6-р сарын эхэнд 26.3 мянган иргэн ажил хайж байсны 4.6 мянга буюу 17.6 хувь нь ажилд зуучлагдсан байна. Ажил хайж байгаа иргэдийн ажилд орсон хувийг сар бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл 3-р болон 6-р сард өссөн дүнтэй байна.


ЗУРАГ 1.6 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭДИЙН АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ХУВЬ, сар бүрээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний хагас жилд нийт 20.3 мянган ажлын байрны захиалга ирсний 11.4 мянга буюу 56.0 хувийг эрэлтээр хангаад байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 пунктээр илүү байна. 2021 оны эхний дөрвөн сарын байдлаар ажлын байрны захиалгын эрэлтийг хангасан байдал нь өмнөх оны мөн үеэс бага байсан бол 5-р болон 6-р сард ажлын байрны захиалгын эрэлтийг өмнөх оны мөн үеэс илүү байна.


ЗУРАГ 1.7 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГЫГ ЭРЭЛТЭЭР ХАНГАСАН ХУВЬ, сар бүрээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны эхний хагас жилд ирсэн ажлын байрны захиалгыг эрэлтээр хангасан хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуй, ой, загас барилт, ан агнуурын салбарын 78.5 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын 49.9 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарын 78.6 хувийг эрэлтээр хангасан нь өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. Харин хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын 70.7 хувь, боловсролын салбарын 76.4 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын 71.4 хувь, уул уурхай, олборлолт салбарын 58.6 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 57.3 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбарын 50.7 хувийг эрэлтээр хангасан боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрэлтийг хангасан хувь нь буурсан байна.


ЗУРАГ 1.8 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, эхний хагас жил, ЭЗҮА-ны салбарын ангилал, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байрны эрэлтийн захиалгыг эрэлтээр хангасан хувийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл, зэвсэгт хүчний ажил, мэргэжил чиглэлээр ирсэн захиалгын 71.4 хувийг, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч чиглэлээр ирсэн захиалгын 57.8 хувийг, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 55.8 хувь, ХАА, ой, загас агнуурын ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 89.1 хувь, худалдаа, үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 49.4 хувь, мэргэжилтэн чиглэлээр ирсэн захиалгын 59.6 хувийг эрэлтээр хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. Харин менежер чиглэлээр ирсэн захиалгын 52.1 хувь, контор, үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 41.4 хувь, энгийн ажил, мэргэжил чиглэлээр ирсэн захиалгын 55.2 хувийг эрэлтээр хангасан боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрэлтээр хангасан хувь бага байна.

ЗУРАГ 1.9 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, эхний хагас жил, ажил мэргэжлийн ангилал, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



## БҮЛЭГ 2.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллага, даатгуулагч болон шимтгэлийн орлого, ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэд гэх мэт хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг энэ бүлэгт авч үзнэ.

### ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА

2021 оны эхний хагас жилийн байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 48.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.0 мянга буюу 4.2 хувиар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 90.6 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 9.4 хувь нь төсвийн байгууллага байна.

#### ХҮСНЭГТ 2.1 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	9 692	9 692	2 815	2 815	- 6 877	-71.0
II	39 687	29 995	38 631	35 816	- 1 056	-2.7
III	42 862	3 175	46 242	7 611	3 380	7.9
IV	44 636	1 774	47 970	1 728	3 334	7.5
V	46 206	1 570	48 458	488	2 252	4.9
VI	46 762	556	48 738	280	1 976	4.2

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Шимтгэл төлөгч хувийн аж ахуй нэгж байгууллагын тоо 2021 оны эхний хагас жилийн байдлаар 44.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 1.9 мянга буюу 4.6 хувь өссөн байна. Мөн даатгал төлөгч төсөвт байгууллагын тоо 4.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 24 буюу 0.5 хувиар өссөн байна.

#### ХҮСНЭГТ 2.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, байгууллагын хэлбэр, өсөн нэмэгдэхээр

Сар	2020		2021		Өсөлт/Бууралт	
	Хувийн ААН	Төсөвт байгууллага	Хувийн ААН	Төсөвт байгууллага	Хувийн ААН	Төсөвт байгууллага
I	8 493	1 199	2 459	356	- 6 034	-843
II	35 303	4 384	34 776	3 855	- 527	-529
III	38 286	4 576	41 668	4 574	3 382	-2
IV	40 069	4 567	43 378	4 592	3 309	25
V	41 632	4 574	43 862	4 596	2 230	22
VI	42 185	4 577	44 137	4 601	1 952	24

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар



## ДААТГУУЛАГЧ

Нийгмийн даатгалд даатгуулагчид 2021 оны эхний хагас жилийн байдлаар 962.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.7 мянгаар өссөн байна. Нийт даатгуулагчдын 85.9 хувийг албан журмын даатгуулагч, 14.1 хувийг сайн дурын даатгуулагч бүрдүүлж байна.

### ХҮСНЭГТ 2.3 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	Нийт даатгуулагчид				Сайн дурын	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо
		Албан журмын даатгуулагч	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага			
I	91 521	50 617	24 636	25 981	40 904	4 993	4 050
II	738 140	665 503	452 416	213 087	72 637	10 488	6 295
III	845 802	744 846	503 902	240 944	100 956	18 630	8 218
IV	900 570	777 449	532 103	245 346	123 121	24 860	9 259
V	927 880	799 274	549 683	249 591	128 606	25 453	9 365
VI	962 387	826 246	572 200	254 046	136 141	25 979	9 752

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Албан журмын даатгуулагчийн 69.3 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 30.7 хувь нь төрийн байгууллагын даатгуулагчид байна. Хувийн аж ахуй нэгжийн даатгуулагчид 572.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.9 мянга буюу 2.9 хувиар, төсөвт байгууллагын даатгуулагчид 254.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 5.2 мянга буюу 2.1 хувиар өссөн байна.

### ХҮСНЭГТ 2.4 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, байгууллагын хэлбэр, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Хувийн ААН	Төрийн байгууллага
I	77 979	64 411	24 636	25 981	- 53 343	-38 430
II	455 547	226 097	452 416	213 087	- 3 131	-13 010
III	486 890	237 011	503 902	240 944	17 012	3 933
IV	508 458	239 239	532 103	245 346	23 645	6 107
V	535 898	244 619	549 683	249 591	13 785	4 972
VI	556 274	248 794	572 200	254 046	15 926	5 252

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт сайн дурын даатгуулагчийн тоо 136.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 20.5 мянга буюу 13.1 хувиар буурсан байна. Эхний хагас жилийн байдлаар нийт нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо өссөн боловч сайн дурын даатгуулагчдын тоо буурсан байна. Сайн дурын даатгуулагчдын 19.1 хувийг малчид, 7.2 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байна.


### ХҮСНЭГТ 2.5 САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он			2021 он		
	Нийт	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	Нийт	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо
I	41 789	10 549	6 142	40 904	4 993	4 050
II	81 302	18 993	12 273	72 637	10 488	6 295
III	108 042	25 962	16 149	100 956	18 630	8 218
IV	120 939	31 050	17 398	123 121	24 860	9 259
V	144 324	40 969	20 084	128 606	25 453	9 365
VI	156 624	46 028	21 002	136 141	25 979	9 752

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2021 оны эхний хагас жилд нийт сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар буурсан байна. Сайн дурын даатгуулагчийг сар бүрээр салгаж үзвэл 3-р болон 4-р сард даатгуулсан сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн байгаа бол бусад саруудад өмнөх оны мөн үеэс буурсан дүнтэй байна.

ЗУРАГ 2.1 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

**Малчид:** 2021 оны эхний хагас жилийн байдлаар сайн дураар даатгуулсан малчид 26.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 20.0 мянга буюу 43.6 хувиар буурсан байна.

**Хувиараа хөдөлмөр эрхлэгч:** Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч 2021 оны эхний хагас жилийн байдлаар 9.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 11.2 мянга буюу 53.6 хувиар буурчээ.

### ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн санд нийт 942.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна. 2019 оны мөн үеэс 113.2 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 220.5 тэрбум төгрөг буюу 30.5 хувиар өссөн дүнтэй байна. Шимтгэлийн орлогын 87.3 хувийг тэтгэврийн, 6.1 хувийг тэтгэмжийн, 5.2 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, 1.3 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна.


ХҮСНЭГТ 2.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	131.8	131.8	121.2	121.2	-10.6	-8.1
II	271.4	139.6	264.2	143.1	-7.1	-2.6
III	420.5	149.1	437.9	173.7	17.4	4.1
IV	520.2	99.7	585.0	147.1	64.8	12.5
V	618.1	97.9	745.2	160.2	127.1	20.6
VI	721.7	103.5	942.1	196.9	220.5	30.5

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2021 оны 1-р сард 121.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 10.6 тэрбум төгрөгөөр бага байсан бол 6-р сард 196.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 93.4 тэрбум төгрөг буюу 90.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 2.2 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны эхний хагас жилийн байдлаар 822.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 254.4 тэрбум төгрөг буюу 44.8 хувиар өссөн байна. Харин өмнөх улирал буюу 2021 оны 1-р улиралд нэмэгдсэн орлогоос 51.5 тэрбум төгрөгөөр их байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны эхний хагас жилийн байдлаар 57.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.9 тэрбум төгрөг буюу 18.3 хувиар буурсан байна. Харин өмнөх улирал буюу 2021 оны 1-р улиралд нэмэгдсэн орлогоос 6.8 тэрбум төгрөгөөр их байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны эхний хагас жилийн байдлаар 49.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.4 тэрбум төгрөг буюу 27.1 хувиар буурсан байна. Харин өмнөх улирал буюу 2021 оны 1-р улиралд нэмэгдсэн орлогоос 5.0 тэрбум төгрөгөөр их байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны эхний хагас жилийн байдлаар 12.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөг буюу 17.6 хувиар буурсан байна. Харин өмнөх улирал буюу 2021 оны 1-р улиралд нэмэгдсэн орлогоос 3.0 тэрбум төгрөгөөр бага байна.

ХҮСНЭГТ 2.7 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, сангийн төрлөөр, тэрбум төгрөг, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он				2021 он			
	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл
I	104.1	12.8	12.3	2.6	98.3	10.6	10.1	2.2
II	213.9	26.4	25.4	5.6	214.3	23.2	21.9	4.8
III	331.8	40.8	39.2	8.8	385.5	25.3	22.2	4.9
IV	410.6	50.4	48.4	10.9	523.5	29.8	26.1	5.6
V	488.6	59.7	57.0	12.9	664.9	37.4	35.9	7.0
VI	568.1	70.3	67.8	15.4	822.6	57.4	49.4	12.7

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

## АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ

2021 оны эхний хагас жилд нийт 12.2 мянган иргэн ажилгүйдлийн тэтгэмж авсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.6 мянга буюу 15.0 хувиар өссөн байна. 2020 оны эхний хагас жилд сард дунджаар 1.8 мянган хүн ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байсан бол 2021

оны эхний хагас жилд сард дунджаар 2.0 мянган хүн ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байна.

**ХҮСНЭГТ 2.8 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО, өсөн нэмэгдэхээр**

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	2 076	2 076	2 887	2 887	811	39.1
II	3 662	1 586	4 624	1 737	962	26.3
III	5 268	1 606	6 938	2 314	1 670	31.7
IV	7 498	2 230	8 323	1 385	825	11.0
V	9 376	1 878	10 246	1 923	870	9.3
VI	10 622	1 246	12 216	1 970	1 594	15.0

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 2021 оны эхний хагас жилийн байдлаар 26.6 тэрбум төгрөг болж, 2019 оны мөн үеэс 7.4 тэрбум төгрөг буюу 38.8 хувиар, 2020 оны мөн үеэс 0.6 тэрбум төгрөг буюу 2.2 хувиар өссөн байна. 2019 оны эхний хагас жилд сард дунджаар 3.2 тэрбум төгрөг, 2020 оны эхний хагас жилд сард дунджаар 4.3 тэрбум төгрөг, 2021 оны эхний хагас жилд сард дунджаар 4.4 тэрбум төгрөг ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан зардал өмнөх онуудаас өссөн дүнтэй байна.


**ХҮСНЭГТ 2.9 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, сая төгрөг, өсөн нэмэгдэхээр**

Сар	2019 он	2020 он	2021 он	2019-2021		2020-2021	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
I	3 427	4 949	4 337	909	26.5	- 612	-14.1
II	6 143	8 750	8 925	2 782	45.3	175	2.0
III	9 022	12 897	13 556	4 534	50.3	659	4.9
IV	12 258	17 040	18 203	5 944	48.5	1 162	6.4
V	16 183	21 629	22 745	6 562	40.5	1 115	4.9
VI	19 188	26 055	26 632	7 444	38.8	576	2.2

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2020 оны эхний хагас жилийн байдлаар нэг хүнд сард дунджаар 2.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж өгч байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар сард дунджаар нэг хүнд 2.3 сая төгрөг зарцуулсан байна. Нэг хүнд зарцуулсан дундаж зардал өмнөх оны мөн үеэс буурсан байна.

**ЗУРАГ 2.3 НЭГ ХҮНД ЗАРЦУУЛСАН ДУНДАЖ ХӨРӨНГӨ, сая төгрөг, сараар**



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

### **БҮЛЭГ 3. ДҮГНЭЛТ**

2021 оны 6-р сарын байдлаар ажил хайж байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.0 хувь буурсан дүнтэй байгаа ч 3-р сараас эхлэн ажил хайж байгаа болон бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өсөж байгаа нь иргэдийн ажил хайх боломж болон сонирхол нэмэгдэж байгааг харуулж байна.

2021 оны эхний хагас жилд нийт 20.3 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 27.4 хувь буурсан ч 6-р сард ирсэн ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өссөн. Мөн 6-р сард ажил хайж байгаа иргэдийн 17.6 хувь нь ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.5 пунктээр их байна. 2021 оны эхний хагас жилийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан дүнтэй боловч 5-р болон 6-р сард ажил хайж байгаа иргэд, ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн хөдөлгөөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 7.7 мянгаар буурсны 71.5 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, 19.2 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар эзэлж байгаа бол ажил зуучлагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 3.8 мянгаар буурсны 19.7 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбар, 42.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар эзэлж байна. Эндээс дээрх хоёр салбар Ковид-19 хамгийн ихээр нөлөөлж байна гэж үзэж болохоор байна. Харин бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ирсэн ажлын байрны захиалга болон ажилд зуучлагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байгаа нь Ковид-19 нөлөө харьцангуй бага байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн эрхлэлтийн хөдөлгөөний тоо мэдээллээс харахад 4-р сарын ажил хайж байгаа иргэдийн тоо, ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад дунджаар 2 дахин бага байгаа нь олон нийтийн хөл хорио болон орон нутаг руу зорчих хөдөлгөөнийг хаасантай холбоотой байх магадлалтай юм. Харин 6-р сарын байдлаар дээрх үзүүлэлтүүд өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. Олон нийтийн хөл хорио нь хөдөлмөр эрхлэлтийн хөдөлгөөнд хүчтэй сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллагын тоо 48.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.0 мянгаар, даатгуулагчдын тоо 962.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.7 мянгаар өссөн боловч сайн дурын даатгуулагчийн тоо 128.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 20.5 мянгаар буурсан байна. Нийгмийн даатгал төлөгч байгууллага болон албан журмын даатгуулагчийн тоо өсөж, сайн дурын даатгуулагчийн тоо буурсан байгаа нь Ковид-19 нөлөө албан бус салбарт илүү их нөлөөлж байгаа нь харагдаж байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 12.2 мянган иргэн ажилгүйдлийн тэтгэмж авсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 15 хувиар өссөн байна. Мөн ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 26.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар өссөн байна.